



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/2024

Булган

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгагдсан Сумдын эрүүл мэндийн төвд мобайл технологийн тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан Улаанбаатар хотын “Чоно гол трейд” ХХК-тай 134 134 000 /нэг зуун гучин дөрвөн сая нэг зуун гучин дөрвөн мянга/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Эрүүл мэндийн газрын дарга /С.Нарантуяа/-д олгосугай.

2. Нийлүүлж буй бараанд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Эрдэнэбаатар/, Эрүүл мэндийн газрын дарга /С.Нарантуяа/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Мобайл технологийн тоног төхөөрөмжийг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу нийлүүлж, хүлээлгэн өгөхийг “Чоно гол трейд” ХХК-ийн захирал /Ө.Байгалмаа/-д даалгасугай.

4. Энэхүү ажлыг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу 2019 оны Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Д.Батцогт/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ